



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 335

Улаанбаатар хот

Г Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл¹ олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын өрөнхий прокурорын газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн, нийт 79,000,000.00 (далан есөн сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, засаж сэлбэн ашиглах зорилгоор хавсралтад заасны дагуу Завхан, Хөвсгөл аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын өрөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, хавсралтад заагдсан Прокурорын газрын дарга, Завхан, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд (хавсралтад заасан)-д эзэмшүүлэх, засан сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д -д бүртгэх;

2.4. Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уурэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001151

15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны дугаар сарын 01-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛАГУУДЫН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАРСААЛТ**

Д/д	Автомашины нэр, төрөл, Улсын болон арлын дугаар	Үйлдвэрлэгдсэн, ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хурийтлагдсан элэгдэл (төгрөг)	Автомашиний эзэмшигч байгууллагын нэр	Хөрөнгө бүртгэх (эзэмших байгууллагын нэр)
6	Ниссан патрол маркийн 0539СЭН улсын, JN1TCSY61Z0580980 арлын дугаартай суудлын автомашин	2011/2011	22,000,000.00	Сэлэнгэ аймгийн Мандал сүм дахь Сум дундын прокурорын газар	Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар (Хатгал тосгоны захирагчийн алба)
7	Ниссан патрол маркийн 1941СЭА улсын, JN1TCSY61Z0581048 арлын дугаартай суудлын автомашин	2011/2011	35,000,000.00	Сэлэнгэ аймгийн Сайхан сүм дахь Сум дундын прокурорын газар	Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар
8	Ниссан патрол маркийн 9539ХОУ улсын, JN1TCSY61Z0580870 арлын дугаартай суудлын автомашин	2011/2011	22,000,000.00	Ховд аймаг дахь Прокурорын газар	Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар (Завханмандал сумын Засаг даргын Тамгын газар)
НИЙТ ДҮН			79,000,000.00		
(далан есөн сая)					